

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН  
ТӨСӨЛ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ  
ЭСЭХ АСУУДЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 7 дугаар  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн Су.Батболд**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг холбогдох бусад хуулийн төслүүдийн хамтаар санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн байна.

Хууль санаачлагч төрийн албыг цаашид олон улсын жишигт нийцүүлэх, хууль эрх зүйн орчныг шинэчлэх, бодлого шийдвэрийг оновчтой болгох, улс төрөөс хараат бус, мэргэшсэн, чадварлаг төрийн албыг бүрдүүлэхэд эрх зүйн орчныг шинэчлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэн уг хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг боловсруулжээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо уг төслийг хэлэлцэх эсэх асуудлыг 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэв.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл Төрийн албаны зөвлөл улс төрөөс хараат бус үйл ажиллагаа явуулах зарчмыг тодорхой тусгах, бүрэлдэхүүнд нь талуудын төлөөллийг оролцуулж, нээлттэй зарчмаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, эмч, багш нарыг төрийн үйлчилгээний албанаас гаргаж, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх; Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт төрийн үйлчилгээний албыг төрийн албаны ангиллаас хасаж, харилцааг холбогдох салбарын хууль, тогтоомжоор зохицуулах, төрийн албаны ажилтны нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг бие даасан хуулиар зохицуулах, төрийн албан хаагчдыг улс төрийн шалтгаанаар өөрчлөхгүй байх сэтгэлгээний өөрчлөлтийг хийх, Удирдлагын академийг тусгай хөтөлбөрөөр төрийн албан хаагчдыг мэргэшүүлдэг, давтан сургадаг сургууль болгон өөрчлөх; Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг төрийн албаны нийтлэг соёлыг бий болгон төлөвшүүлэх, төрийн үйлчилгээний албыг төрийн албанаас гаргах, Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрх, бүтцийг хэт нэмэгдүүлэхгүй байх; Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт хангалттай биш байна, төрийн жинхэнэ албан хаагчтай холбоотой харилцааг зохицуулах хууль байх, Төрийн албаны зөвлөлийн буюу байгууллагын хууль шиг болгож болохгүй, Засгийн газар Төрийн албаны тухай хуулийн төслөө Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй хамтатган хэлэлцэх, төрийн албаны улс төрөөс хараат бус байх зарчмыг хэрэгжүүлэх зохицуулалтыг илүү тодорхой тусгах; Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан төрийн албаны тогтворгүй байдалд шүүмжлэлтэй хандаж, сонгуулиар төрийн албатай холбоотой амлалт өгдөг явдлыг таслан зогсоох, Төрийн албаны тухай хуульд байгаа “түр орлон гүйцэтгэгч” гэдэг үгийг хасах, Удирдлагын академийн менежментийг сайжруулах; Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд төрийн албан хаагчийг

бэлтгэдэг тусгай сургуультай болох, Төрийн албаны тухай хуулийн төслийг санаачилсан Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн алба дахь хууль бус завхралыг зогсоох гэж байгаагаа үйл ажиллагаагаараа харуулах, хуулийн төслийн зарим нэр томьёо, зохицуулалтыг боловсронгуй болгох; Улсын Их Хурлын гишүүн А.Бакей Төрийн албаны тухай хуулийг дээдлэн сахих, төрийн албаны соёлын төлөвшилтийг сайжруулах, төрийн албаны эрх зүйн шинэчлэлийг ажил хэрэгч, нухацтай, шуурхай явуулах талаар Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүд бодитой хандаж, анхаарч ажиллах, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын гишүүдийн өргөн мэдүүлсэн төсөлтэй хамтатган хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг тус тус гаргасан болно.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



А. БАКЕЙ